



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/245

Мөрөн сум

Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.29, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.7, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны 03 дугаар тогтоол Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 01 сарын 04-ний өдрийн Н/01 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох (нэг) аж ахуйн нэгжийн нэр, талбайн хэмжээ, байршил, солбицол, тусгай зөвшөөрлийн хугацааг хавсралт ёсоор баталсугай.

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, (П.Мөнхжаргал), Бүрэнтогтох сумын Засаг дарга (А.Аззаяа) нарт даалгасугай.

3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын талбайг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг) -т даалгасугай.

4.Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймаг орон нутгийн орлогод төвлөрүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

5.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6 Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024

6712010769

Аймгийн Засаг даргын 2024
оны 05 дугаар сарын 13-ны өдрийн
А/... дугаар захирамжийн хавсралт

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ТАЛБАЙ, СОЛБИЦОЛ, ХУГАЦАА

№	Аж ахуйн нэгжийн нэр	Сум, талбайн нэр	Талбайн хэмжээ га	Хугацаа		Солбицол	
				Эхлэх	Дуусах	Уртраг	Өргөрөг
1	"Эрдэм- Үүд" ХХК	Бүрэнтогтох сум Туяа баг	25,27	2024 оны 05 сарын 13	2039 оны 05 сарын 13	100 00 38.99	49 38 17.46
						100 00 39.17	49 38 29.09
						100 00 04.41	49 38 29.31
						100 00 04.43	49 38 17.4

ооо